

НЭВТРҮҮЛЭГЧ, ХӨТЛӨГЧИЙН ТУХАЙ АСУУДАЛД

Л. Амарзаяа*

* РТДС-ийн тэнхмийн эрхлэгч, доктор.

Түлхүүр үг: нэвтрүүлэгч, хөтлөгч, хөтлөх урлаг, эфирийн соёл, шууд нэвтрүүлгийн хөтлөгч, нэвтрүүлэгч.

Нэвтрүүлэгч, хөтлөгчийн тухай. Нэвтрүүлэгч, хөтлөгч нь хоёр өөр ойлголт уу, нэг ухагдахууны хоёр тал уу? Эсвэл эдгээр нэр нь холимог (гибрид) шинжтэй эсэх талаар тодруулъя.

“Нэвтрүүлэгч”, “Хөтлөгч” гэдэг үгийг Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-д “нэвтрүүлэгчийх үүрэг бүхий хүн¹, хөтөлдөг хүн² гэж тайлбарлаад нэвтрүүлэгчийг радио нэвтрүүлэгч, суртал нэвтрүүлэгч гэж ялгажээ. Энэхүү хоёр нэрлэлт нь чухамдаа бол “нэвтрүүлэх, хөтлөх” гэсэн үйл үгнээс үүдэлтэй. Уг тольд нэвтрүүлэхийг тараан дэлгэрүүлэх³, хөтлөхийг юмнаас барьж дагуулан явах, шилжсэн утгаар бол удирдан залж дагуулах⁴ гэжээ. Эндээс радио, телевизийн нийтлэл нэвтрүүлгийг олон түмэнд хүргэхээр тараан дэлгэрүүлэгч нь нэвтрүүлэгч, сонсогч, үзэгчдийг удирдан залж дагуулагч нь хөтлөгчид гэж ойлгож болохоор байна. Энэ шинж нь нэвтрүүлэгч, хөтлөгчийн ажлын чиглэл, ялгааг тодорхойлоход чухал тулгуур болох боловч хөтлөгч, нэвтрүүлэгчдэд тавих шаардлага, үүрэг хариуцлага нь ижил байдаг.

Нэвтрүүлэгчдэд сайхан дуу хоолой, зөв тод дуудлага, ярианы өндөр соёл, мэдлэг боловсрол, авхаалж самбаа, ургуулан бодох чадвар, тэсвэр тэвчээр зэрэг бусад ажил мэргэжлээс ялгарах онцлог шинж бий. Тэд бусдын бичсэнийг зөвхөн уншигч гүйцэтгэгч төдий биш, зохиогчийн санааг ойлгож, сэдвийнхээ гүнд нь орж, үг, өгүүлбэр бүрийг дуу хоолойны өнгө, хэмнэл, хэлж ярьж байгаа намба төрхөөрөө зөв илэрхийлэн, үзэгч, сонсогчидтой ойр дотно хандаж, харилцаж чаддаг байх учиртай. Иймд тухайн нэвтрүүлэгч, үйл ажиллагааг сайхан хөтөлнө гэдэг нэвтрүүлэгч, хөтлөгчийн авьяас, мэдрэмж, авхаалж шаардсан хэрэг юм. Чухам үүнийг сэтгүүлч, редактор буюу зохиогч нь өөрөө гардан гүйцэтгэв үү, эсвэл тухайн бүтээл нэвтрүүлэгч, хөтлөгчийн чадвараар илрэв үү гэдэг нь хөтлөх үр зүйтэй холбогдоно. Гэтэл зарим улс оронд хөтлөлтийг чөлөөтэй явуулах боломж хязгаарлагдмал байдаг. Тухайлбал, Хятадад “радио телевизийн хөтлөгч нь заавал намын дуу хоолой, төрийн бодлогын хүчтэй ухуулагч”⁵ гэж үздэг байна.

Өвөр Монголын радио нэвтрүүлгийн хорооны монгол хэлний шууд нэвтрүүлгийн анхны хөтлөгч Х.Оюун “программын хөтлөгч” (host), “хөтлөгчтэй нэвтрүүлэг” (anchor)-ийн ялгааг тодотгожээ. Тэрбээр “Хөтлөгчтэй нэвтрүүлэг нь нэвтрүүлэх

ажлын нэгэн хэлбэр бөгөөд хөтлөгч нь яг л сонин сэтгүүлийн тусгай бүлгийн зохиолч шигээр программын бүх агуулгаа хөтөлж байдаг. Программын хөтлөгч гэдэг бол радио, телевизийн программыг эзэмших буюу шийдвэрлэдэг хүн⁶ гэж тайлбарласан байна. Мөн Өвөр Монголд хэрэглэдэг "Даамал" (dagagamal) гэсэн нэрлэлтийг "аж ахуй, ар талын ямар нэгэн ажил хэргийг хариуцдаг хүн бөгөөд нийтэд нэвтрүүлэгчийн утгаар хэрэглэдэг болсон"⁷ гэжээ. Түүний бичсэнээр "anchor" буюу сонин мэдээний хөтлөгч нь нэвтрүүлэгч, "host" буюу мэдээний бус программын хөтлөгч нь биднийхээр хөтлөгч гэсэн нэрлэлттэй тохирч байгаа юм.

Манайхан мэдээ нэвтрүүлж байгаа хүнээ голдуу нэвтрүүлэгч гэж ойлгож, харин хөтлөгчийн тухайд зохиогч өөрөө хөтөлж байгаа бол хөтлөгч редактор, бусдын нэвтрүүлгийг хөтөлж байгаа бол хөтлөгч гэсэн нэр томъёоллоор ялгадаг. Уншдаг нь нэвтрүүлэгч, ярьдаг нь хөтлөгч гэж ойлговол ташаарал болно. Бидний ажиглалтаас үзэхэд аливаа улсын радио, телевизийн нэвтрүүлэгт мэдээний төрөлд нэвтрүүлэгч (диктор, anchor, broadcaster), бусад нэвтрүүлгийн төрөлд хөтлөгч (ведущий, announcer, host) гэсэн тайлбартай байгаа нь угтаа судлаач Х.Оюуны тодорхойлолттой дүйж байна. Мөн "Теле", "Радио" гэж ялгадаг нь тухайн нэвтрүүлэгч, хөтлөгчийн ялгааг улам тодотгодог. Гэтэл манайд энэ мэтээр ялгасан нэрлэлт үгүй бөгөөд бүр радио, телевиз, тайзны хөтлөлтийн алийг ч чадварлаг гүйцэтгэдэг нэвтрүүлэгч, хөтлөгч цөөнгүй байдаг. Энэ нь Монголын хөтлөгч, нэвтрүүлэгчдийн хөтлөх ур зүйн хөрвөх чадвар сайтайг илтгэж байна.

Аливаа нэвтрүүлэг болон арга хэмжээг

- Нэвтрүүлэгч (диктор, broadcaster, anchor)

- Хөтлөгч (ведущий, announcer, host)

- Шууд нэвтрүүлгийн нэвтрүүлэгч, хөтлөгч (диктор трансляций, ведущий трансляций, transmitter) гэсэн үндсэн хэлбэрээр хөтлөн явуулдаг байна. Эдгээрийн онцлогийг тодруулъя.

Нэвтрүүлэгч (диктор, anchor, broadcaster) мэргэжил нь хөтлөгчөөс өмнө радио, телевиз үүсэхтэй зэрэгцэн бий болжээ. Аливаа улс оронд анхлан "Нэвтрүүлэгч" л радио, телевизийн дуу хоолой, төлөөлөл болж байв. Хуучнаар ЗХУ-д нэвтрүүлэгчийг "нам, засгийн гадаад, дотоод бодлогын асуудлыг нарийн сайн ухаардаг, тухайн үед манай орны өмнө ямар зорилт тулгарч байгааг арван хуруу шигээ мэддэг, олон улсын үйл явдлыг сайтар баримжаалдаг, өргөн их боловсролтой байх ёстой"⁸ гэж тодорхойлж байжээ. Америкт нэвтрүүлэгчдийг "Эх очивэр уншдаг хүн" хэмээн нэрлэж байгаад сүүлд нь хөтлөгч болгон өөрчилсөн байна⁹.

Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, нэвтрүүлэгч Б.Хишгээ "Нэвтрүүлэгч хүн эх орон, төр засаг, ард түмнийхээ өндөр их алдар хүнд, үзэл бодол, хүсэл эрмэлзлийг илэрхийлэн ярьж хэлэх итгэл хүндэтгэлийг хүлээсэн, унших хөтлөх авьяастай, үгийг ухаарч ойлгох мэдрэмж сайтай, мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшсэн, онцгой үүрэг хариуцлага хүлээсэн, төр түмний дуу хоолой болсон хүмүүс"¹⁰ гэжээ. Мөн "Таны хувьд нэвтрүүлэгч байна гэдэг?" гэсэн асуултанд Соёлын гавьяат зүтгэлтэн, нэвтрүүлэгч Б.Хишгээ, Б.Рагчаа, Г.Чулуунбат, нэвтрүүлэгч Д.Цоодол, Б.Гантигмаа нар "авьяас, сайхан дуу хоолой, хурц хэллэг, авхаалж самбаа, хөдөлмөр, жүжиглэлт, нэр хүндтэй сайхан мэргэжил"¹¹ гэж хариулжээ.

"Нэвтрүүлэгч нь уран тод уншлагаар голчлон эх бичгийг дуу, сэтгэлээрээ амилуулан ажилладаг" гаасаа болоод нэвтрүүлэх нь нэгэн зүйлийн урлаг болдог"¹² тухай Өвөр Монголын алдарт нэвтрүүлэгч Х.Оюун онцолсон байна. Нэвтрүүлэгч нь хөтлөгчийг бодвол сонсогч, оролцогчийг байнга удирдан залах нь бага, харин сонсогч, үзэгчдэд мэдээлэл хүргэх, сэтгүүлчийн бэлтгэснийг дамжуулах үүргийг голчлон гүйцэтгэдэг. Гэхдээ энэ нь нэвтрүүлэгчийн ажлын хөдлөшгүй гол шинж биш юм. Нэвтрүүлэгч хөтлөлттэй нэвтрүүлэгт оролцох бол сонсогч, үзэгчтэй харилцах, тэднийг нэвтрүүлгийн сэдэвт хандуулан удирдах л болно. Хөтлөлтийн явцад хэл ярианы баялагтай байх, зөв онож хэрэглэхийг чухалчилдаг бол нэвтрүүлэхэд уншиж илэрхийлэх аргууд тод илэрдэг. Зарим нэвтрүүлэгчид хөтлөх боломж, чадвар байдаг ч уншилтын арга барилд автаж, загварт баригдах тохиолдол бий. Тиймээс хөтлөгч шиг чөлөөтэй хөтлөх тал дээр учир дутагдалтай байдаг. Радио, телевизээр мэдээ нэвтрүүлэх, эсвэл дүрд хувилан тоглох, шууд ярилцлага өрнүүлж хөтлөх зэрэг нь хоорондоо ялгаатай тул эдгээрт нэвтрүүлэгч, хөтлөгч бүрийн ур чадвар харилцан адилгүй юм. Тухайлбал, "жүжигт тоглолт голлож, нэвтрүүлэгчийн тайлбар дагалдсан аястай байдаг"¹³ бол мэдээллийн нэвтрүүлэгт ойлгомж-

той, товч тодорхой, хөнгөн уншилт голлодог.

Өнөө үед хөтлөлтийн хэв маягийг чухалчлах нийтлэг хандлага бий болсноос үүдэн нэвтрүүлэгчийн байр суурь багасч, хөтлөгчийн цаг үе эхэлж байгаа мэт ойлговол учир дутагдалтай юм. "Японы алдарт NHK телевиз жилд 25 нэвтрүүлэгч ажилд авдаг бөгөөд тэдгээрийн зөвхөн 5 нь эмэгтэй нэвтрүүлэгч байдаг"¹⁴ тухай NHK-ийн нэвтрүүлэгч

эмэгтэй Миада Осамуи "Өнөөдөр" сонины сурвалжлагчид өгсөн ярилцлагадаа дурдсан байна. Мөн "Америкийн дуу хоолой" радио станцын интернэт дэх вэб¹⁵ хуудсанд Олон улсын нэвтрүүлэгчийг зохих болзолтойгоор (11-р сард 50 593 долларын цалин амлаж) сонгон шалгаруулах тухай зарлал гарчээ. Эдгээр жишээ

«

*Нэвтрүүлэгч нь хөтлөгчийг
бодвол сонсогч, оролцогчийг
байнга удирдан залах нь бага,
харин сонсогч, үзэгчдэд мэдээлэл
хүргэх, сэтгүүлчийн бэлтгэснийг
дамжуулах үүргийг голчлон
гүйцэтгэдэг. Гэхдээ энэ нь
нэвтрүүлэгчийн ажлын хөдлөшгүй
гол шинж биш юм. Нэвтрүүлэгч
хөтлөлттэй нэвтрүүлэгт
оролцох бол сонсогч, үзэгчтэй
харилцах, тэднийг нэвтрүүлгийн
сэдэвт хандуулан удирдах л
болно*

»

нь гадаад улс оронд нэвтрүүлэгчийн нэр хүнд, шалгуур, эрэлт хэрэгцээ ямар түвшинд байгаагийн илрэл юм.

Хөтлөгч (ведущий, announcer, host). Үүнд радио, телевиз, тайз, албан байгууллага, тухайн арга хэмжээг хөтөлж буй бүх хөтлөгчид хамаарна.

Хуучнаар ЗХУ-д хөтлөгчийг "бүх талын боловсролтой, амьдралын их туршлага, мэдлэгтэй, оюун ухааны чадамжтай, авхаалжтай, хошигнож чаддаг, тэвчээртэй, шургуу, бүтээлч, хийсвэр сэтгэлгээ сайтай, идэвх зүтгэлтэй, зоригтой, даруу, өөртөө итгэлтэй, олон түмэнтэй эвсэг

ханддаг хүн байх ёстой"¹⁶ гэж тодорхойлж байв.

Радио, телевизийн хөтлөгчдийн хувьд студид бичлэг хийлгэж болох боловч нэвтрүүлгээ ихэвчлэн шууд хөтөлдөг. Тэд нэвтрүүлэгт оролцогчдыг танилцуулж, төлөвлөсний дагуу нэвтрүүлгийг үргэлжлүүлэн, микрофоны өмнөх яриа хөөрөөг чиглүүлж, бас сонсогч, үзэгчтэй утсаар харилцдаг. Явцуу утгаараа хөтлөгч гэдэг нь сонсогч, үзэгчдийг тухайн нэвтрүүлгийн орчинд дагуулан явах хөтөч бөгөөд өргөн утгаараа бол сонсох, тунгаан боловсруулах, ярих, илтгэх, жүжиглэх урлагийн олон талт мэдрэмж шаардагдах мэргэжил гэж ойлгож болно.

Оросын судлаачдын бичсэнээр "Радио болон теле нэвтрүүлэг, арга хэмжээг эрхлэн явуулдаг хөтлөгчид нь харилцан адилгүй. Үүнд:

- Нэвтрүүлгийн эх бичвэрийг бичсэн зохиогч, сэтгүүлч өөрийнхөө нэвтрүүлгийг хөтлөх

- Бусдын бичсэнийг жүжигчид болон хөтлөгч өөрийн болгон хөтлөх

- Мэргэжлийн (хуульч, зохиолч, багш, сэтгэл зүйч гэх мэт) хүмүүсийг хөтлөгчөөр урин ажиллуулж болно.

- Тайзны хөтлөгч нь өвөрмөц үүрэгтэй бөгөөд тэд үйл явдлын нөхцөл байдлыг тайлбарлаж, цаг хугацаа, орон байрыг хэлж өгөх"¹⁷ бөгөөд хөтлөлт нь үзэгчдэд одоо цагт хүрч байдгаараа зарим хөтлөлтөөс ялгарна.

Өнөө үед хүндээ хандаж, харьцаж хүргэх нь давамгайл болж байгаа утгаараа хөтлөлтийг сайн явуулж чадах хөтлөгчийг чухалчлах болсон төдийгүй хөтлөлт нь шууд хэлбэрээр байх нь түгээмэл байна.

Шууд нэвтрүүлгийн нэвтрүүлэгч, хөтлөгч (диктор трансляций, ведущий трансляций, transmitter). Шууд нэвтрүүлгийг мэргэшсэн туршлагатай хөтлөгч, нэвтрүүлэгчид хийж гүйцэтгэх нь олонтаа байдаг. Тухайлбал, улсын баяр наадам, сар

шинийн баяр, ёслолын ажиллагаа, УИХ-ын чуулганы нээлт, хаалтын ажиллагаа зэрэг нэвтрүүлгийг ихэвчлэн шууд дамжуулах тул хөтлөгч, нэвтрүүлэгч нь нэн хариуцлагатай үүргийг хүлээдэг. Тэдний хэлсэн үг, өгүүлбэр бүр нь ямар ч засваргүйгээр сонсогч, үзэгчдэд хүрдэг учраас онцгой хариуцлага, мэдрэмж, авьяас, авхаалж самбааг шаардана. Радио, телевизийн нэвтрүүлгээс гадна цайллага, шоу, концерт, хурим, хурлын ажиллагааг мөн л шууд хэлбэрээр хөтөлдөг. Иймд хөтлөгч, нэвтрүүлэгч нь тухайн нэвтрүүлэг, арга хэмжээг хөтлөхийн тулд хувийн бэлтгэлийг сайтар базааж, холбогдох судалгааг хийснээр амжилт бүтээмж тодорхойлогдоно.

Нэвтрүүлэгч, хөтлөгчийн хөдөлмөрийн бүтээмж, үр дүн нь бодитой, материаллаг зүйл байдаггүй. "Бүтээмж нь эцсийн эцэст хүний оюун ухааны тамир тэнхээний хэрэг бөгөөд хөгжих, дэвших, байгаа бүхнийг сайжруулахад бие, сэтгэлээрээ тэмүүлэхийг хэлдэг"¹⁸ бөгөөд энэ нь олон нийтийн оюун санаанд хүрч үйлчилдэг нэвтрүүлэгч, хөтлөгчдийн ажлын бүтээмжийг тодорхойлох чухал үндэслэл юм.

Аливаа "бүтээмжийн зорилтыг хангахад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн зүгээс хэрэгцээ хангагдах чанарын шаардлага хангасан байх яг цаг хугацаанд нь хүргэх гэсэн үзүүлэлтүүдийг"¹⁹ харгалздаг бөгөөд сонсогч, үзэгч нэвтрүүлэг, арга хэмжээний дараа хөтлөлт, уншилтын хувьд хэр сэтгэл ханамжтай байх нь мэргэжлийн "Нэвтрүүлэгч, хөтлөгч"-ийн хөдөлмөрийн бүтээмжийг тодорхойлж буй хэрэг юм. Иймд нэвтрүүлэг, арга хэмжээний эцсийн бүтээмжийг сайжруулахын тулд нэвтрүүлэгч, хөтлөгчдөд хөтлөх ур зүйн зохих шаардлагуудыг тавьдаг. Хөтлөх ур зүй нь хөтлөгчийн үүсэл,

хэрэгцээнээс шалтгаалан хөгжиж ирсэн талаар тодруулан авч үзье.

Хөтлөгчийн үүсэл, хэрэгцээ.

Мэргэжлийн үүднээс авч үзвэл, нэвтрүүлэгч ба сэтгүүлчийн ажлын хосолсон хэлбэр болсон хөтлөлт нь үзэгч, сонсогчидтой шууд харилцах боломжийг олгодог нь "Хөтлөгч"-ийн давуу талыг тодотгодог. Тиймээс дэлхийн сэтгүүл зүйн өнөөгийн чиг хандлага хөтлөгчийг чухалчилж, мэргэжлийн түвшинд үнэлэн авч үзэх болов.

"Хөтлөлт", "хөтлөгч" гэсэн ойлголт яаж үүссэн тухай баримт сөхвөл, анхны хөтлөгчийг Америкийн Муруу гэж үздэг байна. Тэр радио нэвтрүүлгийн нэртэй сэтгүүлч байсан ч телевизийн хөтлөгчдийн анхны үлгэр дуурайл болж чадсан юм. "Дэлхийн II дайны дунд үед "Мүникэгийн хэрэг" явдлыг нүдээр үзсэний хувьд байдлыг газар дээрээс нь мэдээлж, бөмбөгдүүлсэн дэлгүүр дотор сумны хэлтэрхийд цоорсон тоорын хажууд микрофоноо тавиад жимсний шүүс шалан дээр удаахан нэгэн жигд дуслах чимээгэр агаарын дайралтын чөлөөн дэх өчүүхэн хоромын аймшигт нам гүм байдлыг радиогоор сонсгон нэвтрүүлж байжээ. Тэр бас Германы нисэх онгоцууд бөмбөгдөхөөр ирж байхад Лондон хотын нэг асрын орой дээр зогсоод ахуй байдлыг мэдээлж, алс хол Америкийн сонсогчдод аюулт дайны үнэн байдлыг тодорхой ойлгуулж байв. Ийнхүү дайн төгсөхөд Муруу Америкийн баатар, нэрт хүн болж чаджээ."²⁰ Эндээс харахад хөтлөлт гэдэг нь радиогоор үйл явдлыг дүрслэн илэрхийлэх, шууд нэвтрүүлэхээс үүссэн байна.

Монгол улсад энэ хэлбэр нь 1940-аад онд хийж байсан анхны радио сурвалжлагаас эхтэй юм. 1942 оны 2-р сарын 22-нд Д.Сүхбаатарын үйл амьдралыг сурталчлахад зориулсан радио өдөрлөг зохиож,

нүүдлийн нэвтрүүлэх станцаар Хувьсгалын музей дэх Д.Сүхбаатарын тасгаас нэвтрүүлэг хийсэн нь манай анхны радио сурвалжлага болсон түүхтэй. Тэр цагт бичлэгийн аппарат гэж байгаагүй учраас шууд дамжуулан нэвтрүүлсэн нь тодорхой юм. Харин 1945 оны 5-р сарын 9-нд Ялалтын баярт зориулсан Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн цуглаанаас сэтгүүлч Х.Намсрайжав шууд сурвалжлага хийж байжээ. Ер нь радиод дүрсэлсэн сурвалжлага хийх, газар дээрээс нь шууд нэвтрүүлж байгаа хүнийг (тэр үедээ бол хөтлөгч юм) "Сурвалжлагч" гэж нэрлэсээр ирсэн.

Сэтгүүлч өөрийн бичиж боловсруулсан эх бичвэр (текст)-ээ сонсогч, үзэгчдэд шууд хүргэх хамгийн шилдэг арга нь өөрөө хөтлөх явдал. Сэтгүүлчийн бэлтгэсэн 100 хувийн мэдээлэл сонсогч, үзэгчдэд ихэвчлэн 90-95 хувьтай хүрдэг байна. 5-10 хувь нь хаачив? Дамжуулах явцад мэдээлэл саарч байгаа нь энэ юм. Үг дамжуулах тоглоомыг бүгд мэднэ. Анхны хэлсэн үг хэдий чинээ олон хүнээр дамжина төдийчинээ хувиран өөрчлөгдөж, заримдаа бүр огт өөр утгатай болдог шүү дээ. Энэчлэн үйл явдлыг газар дээрээс нь сурвалжлан бэлтгэсэн хүн тэрхүү мэдээгээ өөрөө шууд хүргэвэл дээрх 5-10 хувь алдагдахгүй байх боломж бүрэн байдаг. Тиймээс ч өнөөдөр сэтгүүлчдийг хөтлөх чадвартай байхыг шаардах болжээ. Гэхдээ сэтгүүлч болгон өөрөө нэвтрүүлгээ хөтөлсөн тохиолдолд хөтлөгч болчихно гэж ойлговол ташаарал болно. Тааруухан эх бичвэрийг нэвтрүүлэгч, хөтлөгчийн чадварлаг уншилт, хөтлөлтөөр амьдруулж болдог байхад үүний эсрэгээр сайн эх бичвэрээ зохиогч өөрөө хөтөлж байна гээд буруу хазгай уншвал эх бичвэрийн агуулга илэрхийлэл саарч болзошгүй. Тэгэхээр сэтгүүлч бүр хөтлөгч

болж чадахгүй ч хөтлөгч, нэвтрүү-
лэгчдэд мэргэжлийн шаардлага тавьж
чадах хөтлөх ур зүйн мэдлэгтэй байх
хэрэгтэй юм.

Манай улсад радио, телевизүүд
олноор бий болсон нь хөтлөгчийн
эрэлт хэрэгцээг шаардаж байна.
Улаанбаатар хотод гэхэд л FM-106,
FM-107, FM-107.5, FM-102.5, FM-
100.5 зэрэг хэт богино долгионы
арав гаруй радио станц, мөн тооны
(MNTY, MN-25, UBS гэх мэт) телевиз
үйл ажиллагаа явуулж байгаагаас
гадна хөдөө орон
нутагт аймаг, су-
мын төв зэрэг
төлөрсөн газарт
хэт богино дол-
гионы радио стан-
ци, телевизүүд
ажиллах болж,
эдгээрт ур чад-
вар, соёл, мэдлэг
боловсролтой мэр-
гэжлийн хөтлөг-
чид шаардагдах
боллоо.

Өнөө үед за-
рим радио, теле-
визүүдийн эфирт
идэвхтэн хөтлөгч,
оюутнууд болон
мэргэжлийн биш хүмүүс сонир-
хогчийн байдлаар чөлөөт цагаараа
ажиллах болсон нь эфирийн соёл,
ажлын хариуцлага болон тухайн
нэвтрүүлэг, арга хэмжээний хүчийг
сулруулахаас гадна хөтлөгч, хэвлэл
мэдээллийн хэрэгслийн нэр хүнд,
улмаар хөтлөх урлагийн үнэ цэнийг
бууруулахад хүргэж байна. Тэдний
дуу хоолойны өнгө сонсголонгүй,
хэлгий, этгээд бүдүүлэг үг хэллэг
хэрэглэдэг, хоолой засах, амаа
тамшаалах, үгээ зөөх, гар утас нь
дуугарах, гараа дэмий савах, харцаа
гүйлгэн аальгүйтэх, үс гээг, өмссөн
хувцсаа тохируулаагүй зэрэг эфи-
рийн наад захын соёл дутагдалтайн
дээр микрофон, дуран авайтай

харьцах мэдлэггүй, ярианы чадвар
муу байгаа зэрэг нь хөтлөх ур зүйд
нийцэхгүйг анхаарууштай юм.

Цаг үеийн шаардлагаар урган
гарч байгаа хөтлөгчийн эрэлт
хэрэгцээг дагаад хөтлөгч бэлтгэх
мэргэжлийн биш дамжаа, сургалтыг
энд тэнд ажиллуулах болсон нь
хөтлөгч-нэвтрүүлэгчийн ажлыг амар
хялбар, сонирхсон хэн боловч эзэм-
шиж болдог гэсэн явцуу ойлголтыг
олон түмэнд төрүүлж болох билээ.

Харах урлаг (визуальное ис-
кусство) буюу
телевиз, тайз-
наа, сонсох ур-
лаг (авизуаль-
ное искусство)
буюу радиод эх
хэлнийхээ хэм
хэмжээг мэддэг,
баялаг санг
ончтой ашиглаж
чаддаг, төв хал-
хын аялгуугаар
ярьдаг, дуу хоо-
лойн өнгө, хурд
тохирсон, сонс-
голонтой, дүр
төрх нь харахад
нийцтэй, зөв бо-
ловсон харил-

«

*Өнөө үед зарим радио,
телевизүүдийн эфирт идэвхтэн
хөтлөгч, оюутнууд болон
мэргэжлийн бус хүмүүс
сонирхогчийн байдлаар чөлөөт
цагаараа ажиллах болсон нь
эфирийн соёл, ажлын хариуцлага
болон тухайн нэвтрүүлэг, арга
хэмжээний хүчийг сулруулахаас
гадна хөтлөгч, ХМХ-ийн нэр
хүнд, улмаар хөтлөх урлагийн үнэ
цэнийг бууруулахад хүргэж байна*

»

цаатай хөтлөгчийг бэлтгэх шаард-
лага зүй ёсоор тавигдах боллоо.

Манай улсад 1934 онд радио,
1967 онд телевиз үүсч, радио, теле-
визийн нэвтрүүлэгч гэсэн мэргэжил
бий болсноор нэвтрүүлэгч, хөтлөг-
чийн ажлын уламжлалыг өнөө
хүртэл хадгалсаар ирсэн билээ.
Гэхдээ мэргэжлийн төвшинд зөвхөн
хуучнаар ЗХУ-д мэргэжил дээшлүү-
лэн сургаж байсан. Одоо ч мэргэжил
дээшлүүлж байгаа. Харин Монголын
радио, телевизийн хэрэг эрхлэх
газар (МРТХЭГ)-ын харьяа Радио
Телевизийн дээд сургууль (РТДС)-д
сэтгүүлч-хөтлөгчийн сонгон суралцах
ангид гурван жил шаталсан сургалт
явуулж эхэлсэн нь мэргэжилтнээ эх

орондоо бэлтгэх эхлэл төдийгүй, "Хөтлөгч", "Нэвтрүүлэгч" гэдэг нарийн мэргэжилтнийг бэлтгэх боловсон хүчний бодлогод чухал алхам болж байна.

Бидний авч үзэж буй нэвтрүүлэгч, хөтлөгчийн тухай асуудал нь радио, телевиз, тайзны гэсэн мэргэжлийн хөтлөлтийн төрлөөс гадна нийгмийн харилцааны гол этгээд болох байгууллагын үйл ажиллагаанд ч ямар нэгэн хэлбэрээр холбогдон хөтлөх урлагийн онцлогийг тусгаж байдаг.

Хөтлөх урлагийн тухай.

Хөтлөх урлагийн онол, практикийн судалгааг мэргэжлийн радио, телевиз, урлаг соёлын хүрээнд төдийгүй аливаа байгууллагын соёл, менежмент, бизнесийн үйл хэрэг, хүмүүсийн хоорондын харилцаа зэрэг үйл ажиллагааны олон талт харилцаанд хамааруулан авч үзэх болжээ. Жишээлбэл, бизнесийн харилцаанд бараа бүтээгдэхүүнээ сайн сурталчилж, худалдан авагчдыг татахын хирээр наймаа амжилттай болдог. Хэн нэгнийг өөрийн ярианд итгэл үнэмшилтэйгээр хандуулж чадах, хэсэг хүмүүсийг нэг цаг хугацаанд нэгдмэл үйл ажиллагаанд татан оролцуулахын аль аль нь хөтлөлт юм. Аливаа байгууллагын хурал, тэмдэглэлт үйл явдал зэрэг олныг хамарсан арга хэмжээг зохион байгуулахад радио, телевизийн хөтлөгчдийг уриад байдаггүй. Харин яриа хөөрөөтэй, хамт олноо сайн мэддэг, нүүрэмгий нэг нь хөтлөх үүргийг хүлээж "Байгууллагын хөтлөгч" гэж өргөмжлөгддөг. Тэрхүү хөтлөгч нь хөтлөх урлагийн анхны мэдэгдэхүүн ойлголттой, соёлтой байж чадвал хамт олны талархал хүндэтгэлийг хүлээж чадах билээ. Олон хүнийг хамарсан арга хэмжээг хөтөлнө гэдэг амаргүй ч үүнд суралцаж болно. Иймд хөтлөх, ярих урлагийн тухай мэдлэг, ойлголт өгөхөд чиглэсэн сургалтуудыг хэвлэл мэдээл-

лийн газрууд гэлтгүй албан байгууллагуудад ч зохион байгуулах боломжтой.

Урлаг нь бодит байдлыг тусгаж, уран зохиол, театр, хөгжим, кино, дүрслэх урлаг зэрэг төрөл хэлбэрүүдээр илэрдэг. Урлагийн энэ олон төрлийг нэгтгэн шинээр үүсэн бий болсон төрөл нь "Радио, телевизийн урлаг" болохыг судлаачид тэмдэглэдэг байна. Радио, телевиз нь олон түмэнд нөлөөлж, тэдэнд мэдээлж, танин мэдүүлж, хөгжүүлэн хүмүүжүүлж байдаг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (ОНМХ) төдийгүй, харах, сонсох урлаг болдог билээ. Нэгэнт радио, телевиз, тайз зэргийг урлаг гэж хүлээн зөвшөөрч байгаа тул тэдгээрийн бодит илэрхийлэл болсон хөтлөлтийг ч урлаг гэж ойлговол зохино.

Урлагт мэдрэмжтэй хандаж байж түүнийг ойлгоно, эзэмшдэг тул зохих мэдрэмж, авьяас зайлшгүй хэрэгтэй. "Нэг хувийн авьяас, 99 хувийн хөдөлмөрөөр амжилт бий болдог" гэдэг зарчим хөтлөх урлагт ч гол мөрдлөг болдог. Нэртэй илтгэгч, улс төрч Роберт Пеел гоц содон авьяастай байгаагүй ч багадаа дадал хэвшил болгосон байнгын сургуулийн хүчинд өндөр нэр алдарт хүрсэн гэдэг. "Бага байхад нь эцэг нь түүнийг дандаа ширээний өмнө зогсоож, цээжээр яриулдаг байжээ. Пеел ч өөрөө "Шашны номлол"-ыг дахин давтан уншиж, цээжлэхийг зорилго болгож байв. Эхлээд тийм ахицтай байгаагүй ч бага багаар дасгал сургуулиа үргэлжлүүлж байх хооронд анхаарал төвлөрүүлэх чадвар нь нэмэгдсээр нэг мэдэхэд номлолыг үг, үсэг гээхгүй уншиж чаддаг болтлоо сайжирчээ. Дараа нь тэрээр зүйрлэшгүй илтгэх чадвараараа улс төрийн өрсөлдөгчдөө унагааж ирсэн бөгөөд бусдаас гоц зөв цээжлэх чадвар нь багадаа эцгээсээ сурсан дасгал сургуулийн

үр дүн²¹ байв. Хөтлөх ур зүйн чухал чанар нь хөтлөгч, нэвтрүүлэгчийн ой тогтоолт, авхаалж самбаа учир дээрх жишээг дурдав.

Хөтлөх урлагийн гайхамшгийг дэлхий дахинд хүлээн зөвшөөрөх болж, нэрт хөтлөгч, нэвтрүүлэгчид олноор төрөн гарч байгааг бүгд мэднэ. Тухайлбал, алдарт Лари Кингийн чөлөөтэй, илэн далангүй хөтлөлт, оросын нэвтрүүлэгч Г.С. Шумаковын ярианы маягийн уншилт, Монгол улсын

Соёлын гавьяат зүтгэлтэн, нэрт нэвтрүүлэгч С. Гунгаагийн дүрийн хувирал зэргийг жишээлж болно. Монголын үе үеийн үзэгч, сонсогчдын талархлыг хүлээсэн нэвтрүүлэгч, хөтлөгчид манай радио, телевизэд цөөнгүй. Нэвтрүүлэгчийн хөтлөх ур зүйд холбогдох сонирхолтой нэгэн жишээг дурдвал, Доминиканы бүгд найрамдах улсын

"Соль" радиогийн нэвтрүүлэгч Х.Н.Идальго 80 цагийн турш тасралтгүй шууд нэвтрүүлэг хөтөлж, "Гиннесийн ном"-д орох шинэ амжилтыг тогтоосон юм. "Тэр хөтлөлтөө баасан гаригийн өглөө эхэлж, даваа гаригийн үдээс хойш дууссан байна. 80 цаг тасралтгүй ажиллахад нь 12 хүн тусалж, унших текстийг нь засаж, бэлтгэн өгч байжээ. Гиннесийн амжилтын шаардлагын дагуу нэвтрүүлэгч хүн цагт доод тал нь 52 минут тасралтгүй ярих ёстой байсан бөгөөд 15 минут л

амарч байх ёстой гэнэ. Тэрээр сүүлийн 45 цагт нь сонсогчдын асуултанд хариулж байжээ²² Х.Н.Идальгогийн гол зорилго нь улсынхаа нэрийг "Гиннесийн ном"-д оруулах явдал байсан гэдэг.

Радио, телевизийн нэвтрүүлэг аливаа үйл ажиллагааг зохион байгуулахад зохиогчийн санааг өөрийн сэтгэл, зүтгэл, бүтээлч хөдөлмөрөөр баяжуулан үзэгч, сонсогчдод хүргэх онцгой үүргийг гардан гүйцэтгэж, хэрэгжүүлэх эцсийн дамжлага дээр ажилладаг хүмүүс бол нэвтрүүлэгч, хөтлөгчид бөгөөд тэдний ажлын үзүүлэлтээр наанадаж тухайн нэвтрүүлэг, байгууллагын нэр хүнд, цаашилбал улс орны хөтлөх урлагийн хөгжил тодорхойлогдож байдаг.

Хөтлөгчийн соёл, харилцаа, мэдлэг чадвар нь зөвхөн нэвтрүүлэг, үйл ажиллагааны явцыг тодорхойлоод зогсохгүй сонсогч,

үзэгчдэд нөлөөлдөг онцлогтой. Өөрөөр хэлбэл сонсогч, үзэгч хөтлөгчийн хэл ярианы баялаг, ашиглалт, чадвар, зан харилцааг шууд тусган хүлээн авч тэр чинээгээр харилцаж, илэрхийлэхийг эрмэлзэн улмаар ярих болон харилцааны соёлд суралцаж байдаг. Тиймээс хөтлөх урлагт хөтлөгчийн эрүүл ахуй, ёс зүй, соёл, ур зүйн ойлголтуудыг хамааруулдаг юм

Эцэст тэмдэглэхэд, манайд нэвтрүүлэгч, хөтлөгчийн ажил мэргэжлийн онцлог, одоо, ирээдүйн

«

Радио, телевизийн нэвтрүүлэг, аливаа үйл ажиллагааг зохион байгуулахад зохиогчийн санааг өөрийн сэтгэл, зүтгэл, бүтээлч хөдөлмөрөөр баяжуулан үзэгч, сонсогчдод хүргэх онцгой үүргийг гардан гүйцэтгэж, хэрэгжүүлэх эцсийн дамжлага дээр ажилладаг хүмүүс бол нэвтрүүлэгчид, хөтлөгчид бөгөөд тэдний ажлын үзүүлэлтээр наанадаж тухайн нэвтрүүлэг, байгууллагын нэр хүнд, цаашилбал улс орны хөтлөх урлагийн хөгжил тодорхойлогдож байдаг

»

талаар судлан шинжилсэн нь ховор хэвээр байна. Соёлын гавьяат зүтгэлтэн, нэвтрүүлэгч Б.Хишгээгийн "Микрофонтой харьцахад" (УБ., 1998) номоос өөр нэвтрүүлэгч, хөтлөгчдөд ашиглах ном, сурах бичиг хэвлэгдээгүй байсаар байна. Харин ярих, уран яруу өгүүлэх, илтгэх урлаг, уран уншлагатай холбоотой номууд байдаг. Эдгээр нь анхан шатны ойлголт, ухагдахууныг өгөх боловч микрофон, дуран авай (камер)-тай харьцдаг радио, телевизийн нэвтрүүлэгч, хөтлөгчдийн хувьд мэргэжлийн түвшинд ашиглах гарын авлага шаардагдаж байна.

Радио, телевизийн нэвтрүүлэгч, хөтлөгч бэлтгэх сургалтын хүрээнд судлаач миний бие 1985-1992 онд Монголын радиогийн "Хүүхдийн нэвтрүүлгийн хөтлөгч", 1997 оноос "Хөх тэнгэр" радио станцын хөтлөгч-редактораар ажилласан бөгөөд тодорхой судалгаанд үндэслэн 2001 оноос РТДС-д "Хөтлөгчийн уран чадвар" хичээлийг зааж байна. Үе үеийнхний туршлагад дулдуйдан холбогдох материал, ном товхимол сэлтийг судлан үзсэнээ тулгуурлан хөтлөгч, нэвтрүүлэгчийн мэргэжлийн онцлогийг тодотгох, улмаар сэтгүүл зүйтэй холбогдох шижмийг онцлох зорилгоор асуудал дэвшүүлж энэхүү санал дүгнэлтийг дэвшүүлэв. Эрдэмтэн судлаачид энэ чиглэлийн асуудлыг анхаарч, нягтлан судалбал манай орны хөтлөх урлагийн хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлоход тус дэм болох билээ.

Дээр өгүүлснийг нэгтгэн үзвэл:

- Хөтлөх урлаг, ур зүйн асуудал нь мэргэжлийн нэвтрүүлэгч, хөтлөгч, уран илтгэгчдэд хамаарах төдий хэрэг биш бөгөөд дэлхийн сэтгүүл зүйн өнөөгийн чиг хандлага хөтлөгчийг чухалчилж, мэргэжлийн төвшинд үнэлэн авч үзэх болсон байна. Сэтгүүлч хөтлөгч байх албагүй ч

хөтлөх ур зүйн мэдлэгтэй байх шаардлагатай юм.

- Радио, телевизийн нийтлэл нэвтрүүлгийг олон түмэнд хүргэхээр тараан дэлгэрүүлэгч нь нэвтрүүлэгч, харин сонсогч, үзэгчдийг удирдан залж дагуулагч нь хөтлөгчид гэж ойлгож болно. Энэ шинж нь нэвтрүүлэгч, хөтлөгчийн ажлын чиглэл ялгааг тодорхойлоход чухал тулгуур болох боловч тэдэнд тавих шаардлага, үүрэг хариуцлага нь ижил юм.

- Манайд радио, телевизүүд олноор бий болсон нь хөтлөгчийн эрэлт хэрэгцээг шаардах болов. Үүнийг дагаад хөтлөгчийн янз бүрийн сургалт, дамжааг ажиллуулах болсон нь зарим талаар хөтлөгч-нэвтрүүлэгчийн ажлыг амар хялбар, сонирхвол эзэмшиж болдог гэсэн явцуу ойлголтыг олон түмэнд төрүүлэх буйг анхаарах асуудал юм.

- 2000 оноос РТДС-ийн сэтгүүлч-хөтлөгчийн сонгон суралцах ангид шаталсан сургалт явуулж эхэлсэн нь мэргэжилтнээ эх орондоо бэлтгэх анхны алхам төдийгүй мэргэжлийн "Хөтлөгч, нэвтрүүлэгч"-ийг бэлтгэх боловсон хүчний бодлогод чухал үүрэг гүйцэтгэх болов.

- Манайд хөтлөгч, нэвтрүүлэгчийн талаар нарийвчлан үзэж, дагнан судалсан нь үгүй бөгөөд судлаач мэргэжилтнүүд энэ чиглэлийн асуудлыг цаашид анхааран нягталж судлууштай.

Ишлэл

¹ Цэвэл Я. 1966. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. Х. 365.

² Мөн тэнд. Х. 717.

³ Мөн тэнд. Х. 395.

⁴ Мөн тэнд. Х. 717.

⁵ Оюун. 2003. Радио телевизийн программын хөтлөгчийн ухаан. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. Х. 43.

⁶ Мөн тэнд. Х. 9-11.

⁷ Мөн тэнд. Х. 5.

⁸ Нэвтрүүлэгчдэд зориулсан гарын авлага. Орос хэлнээс орчуулсан гар бичмэл. Мон-

голын радиогийн нэвтрүүлэгч Д.Билгээгийн номын сан Х.3

⁹ О ю у н. 2003. Радио телевизийн программын хөтлөгчийн ухаан. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. Х. 15

¹⁰ Х и ш г э э Б. 1998. Микрофонтой харьцахад УБ. Х. 2-3.

¹¹ "Weekend" сонин. 2004. №38 (192).

¹² О ю у н. 2003. Радио телевизийн программын хөтлөгчийн ухаан. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. Х. 16.

¹³ А м а р з а я а Л. 1999. Монголын радиогийн жүжгийн уран сайхны онцлогийн асуудалд УБ. Х. 57.

¹⁴ "Өдрийн сонин". 2002. №285.

¹⁵ <http://www.voa.gov/vacancies/BBG-04-001.htm>

¹⁶ Л ь ю и с Б. 1973. Диктор телевидения. М. С. 78.

¹⁷ 2000. Радиожурналистика. М. С. 461.

¹⁸ "Weekend" сонин. 2004. №38 (192).

¹⁹ Мөн тэнд.

²⁰ О ю у н. 2003. Радио телевизийн программын хөтлөгчийн ухаан. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. Х. 48.

²¹ С м а й л с С. 2001. Өөртөө туслах ухаан. УБ. Х. 24.

²² "Өдрийн сонин". 2002. №285.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. А м а р з а я а Л. 1999. Монголын радиогийн жүжгийн уран сайхны онцлогийн асуудалд. УБ.
2. Л ь ю и с Б. 1973. Диктор телевидения. М.
3. Нэвтрүүлэгчдэд зориулсан гарын авлага. Орос хэлнээс орчуулсан гар бичмэл. Монголын радиогийн нэвтрүүлэгч Д.Билгээгийн номын сан.
4. 2000. Радиожурналистика. М.
5. С м а й л с С. 2001. Өөртөө туслах ухаан. УБ.
6. О ю у н. 2003. Радио телевизийн программын хөтлөгчийн ухаан. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.
7. "Өдрийн сонин". 2002. №285.
8. Х и ш г э э Б. 1998. Микрофонтой харьцахад. УБ.
9. Ц э в э л Я. 1966. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.
10. Э н х с а й х а н С. 1998. Бүтээмжийн тухай орчин үеийн ойлголт. УБ.
11. "Weekend" сонин. 2004. №38 (192).

Вопросы искусства и мастерства ведущего не столь являются делом, относящимся к профессиональным дикторам ведущим и ораторам, но сегодняшнее направление мировой журналистики придает важное значение ведущему и стало оценивать его на профессиональном уровне. Хотя не каждый журналист должен являться ведущим, но он обязан иметь знания о мастерстве и чувствительности.

Можно понимать так, что диктор является распространителем или доводящим до сведения общественности радио и телевизионные передачи, а ведущий является руководителем и предводителем слушателей и зрителей. Хотя это качество является важным, опорным пунктом, определяющим, различие и рабочие направления диктора и ведущего одиноковые.

Появление большого числа радио и телевидения в нашей стране вызвало потребность в ведущих. Вслед за этим, появление различных курсов и кружков по подготовке ведущих породило ограниченное понятие среди общественности, что можно легко овладеть специальностью диктора и ведущего.

Начало организации с 2000 года трехгодичного обучения по подготовке журналистов-ведущих в Высшей школе Радио и Телевидения явилось не только первой пробой по подготовке специалистов у себя на Родине, но и важным шагом в политике по подготовке кадров по специальности "Ведущий. диктор"

Ввиду того, что в настоящее время у нас отсутствуют конкретные и специализированные исследования по вопросам подготовки и деятельности дикторов и ведущих, думается, что необходимо в дальнейшем обратить внимание специалистов, исследователей на эти вопросы.